



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/64

Баян-Овоо

**Хагас жилийн мал тооллого
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.в, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/271 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт хагас жилийн мал тооллогын ажлыг 2024 оны 05 дугаар сарын 27-ноос 06 дугаар сарын 04-ны хооронд зохион явуулсугай.

2.2024 оны хагас жилийн мал тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	Ш.Мөнххуяг	(Засаг даргын орлогч)
Гишүүд	Г.Ган-Эрдэнэ	(Агац багийн Засаг дарга)
	А.Азжаргал	(Онон багийн Засаг дарга)
	А.Анар	(Балж багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Э.Баасанхүү	(Баян-Овоо багийн Засаг дарга)
Нарийн бичгийн дарга	М.Ариунгэрэл	(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2.Хагас жилийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Ш.Мөнххуяг)-т үүрэг болгосугай.

3.Хагас жилийн мал тооллогыг засаг захиргааны нэгжид зохион байгуулахад шаардлагатай заавар зөвлөмжийг өгч, тооллогыг нэг зэрэг хугацаанд нь эхлүүлж, чанартай зохион байгуулж хяналт тавьж, тооллогын шивэлт, дүнг эцэслэн боловсруулж мэдээлэхийг ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга (М.Ариунгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД



010000166